

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/69/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Б.Долгорсүрэн  
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.gov.mn  
Аудитор Н.Нямсүрэн  
Утас: 260512 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn  
Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн захирал Б.Пүрэвдулам  
Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudit09@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

|  |    |
|--|----|
| <b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....                                  | 4  |
| <b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....                                | 6  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                             | 6  |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....                            | 7  |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....                             | 8  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                              | 9  |
| 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....                  | 10 |
| <b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....                              | 11 |
| 3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....                                      | 11 |
| 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....                                     | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                              | 12 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт ..... | 12 |
| 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....                             | 15 |
| <b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....   | 17 |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | 17 |
| 4.2 Материаллаг байдал.....  | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....   | 19 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                 | 21 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                                | 21 |
| <b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....  | 22 |
| 5.1 Төлбөрийн акт .....  | 22 |
| 5.2 Албан шаардлага .....  | 23 |
| <b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....                  | 24 |
| 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....                      | 24 |
| 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....                     | 25 |
| 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....   | 26 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|         |   |
|---------|---|
| АДБОУС  | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БНМАУ   | Бүгд Найрамдах Монгол Ард Улс                 |
| ДДТ     | Дулаан дамжуулах төв                          |
| ДЦС     | Дулааны цахилгаан станц                       |
| ЕСБХБ   | Европын сэргээн босголт хөгжлийн банк         |
| ОСНААУГ | Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар       |
| СТОУС   | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт    |
| ТЗБАХ   | Техник зохион байгуулалтын арга хэмжээ        |
| ТӨБЗГ   | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар     |
| ТӨХК    | Төрийн өмчит хувьцаат компани                 |
| ТЭЗҮ    | Техник эдийн засгийн үзүүлэлт                 |
| ХАДЭХ   | Худалдан авсан дулаан эрчим хүч               |
| ХХК     | Хязгаарлагдмал хариуцлагатай компани          |
| ЭХЗХ    | Эрчим хүчний зохицуулах хороо                 |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/760  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Урт хугацаат өр төлбөр өнгөрсөн оноос 27,721.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх Дэлхий банкны төслийн ашиглалт, улсын төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой. Энэ нь зорилтот түвшинд төлөвлөсөн урт хугацаат өр төлбөрөөс 6,513.6 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд ДЦС 2, 3, 4 болон Амгалан дулааны станцаас 34,892.4 мян.жоуль дулааны эрчим хүч худалдаж авахаар төлөвлөн, гүйцэтгэлээр 34,665.9 мян.жоулийг худалдан авч, төлөвлөснөөс 0.6 хувиар буюу 226.4 мян.жоулиар буурч,

борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 0.08 пункт 6.7 хувиар бууруулж, түгээх сүлжээний алдагдлыг төлөвлөгөөнөөс 0.6 хувиар бууруулж 17.53 хувьд хүргэн ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн өмч нь өмнөх оноос 1,066.8 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн хөрөнгийг 2024 онд эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэснийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 06 дугаар тогтоолоор өөрчлөн бүртгэсэнтэй холбоотой.

Элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах хөрөнгийг дахин үнэлж Төлөөлөн удирдах зөвлөлийн 06 дугаар тогтоолоор 4,063.5 сая төгрөгөөр дахин үнэлгээ данс нэмэгдүүлж, үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан 635.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмчийн бусад хэсэгт 3,864.1 төгрөгийн үнэлгээтэй 2 газар нэмж бүртгэсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар   | Үзүүлэлт                                | 2024 оны 12 сарын 31      | 2025 оны 12 сарын 31      |
|-----------------|---|---------------------------|---------------------------|
| 1.1.1           | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө       | 7,699,690,424.82          | 7,964,654,715.64          |
| 1.1.2           | Дансны авлага                           | 25,144,601,335.59         | 22,929,374,789.40         |
| 1.1.4           | Бусад авлага                            | 2,833,864,269.40          | 2,663,838,528.66          |
| 1.1.6           | Бараа материал                          | 680,977,822.30            | 721,683,514.46            |
| 1.1.7           | Урьдчилж төлсөн зардал/тооцоо           | 117,469,412.29            | 11,905,326,392.87         |
| <b>1.1.11</b>   | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>36,476,603,264.40</b>  | <b>46,184,877,941.03</b>  |
| 1.2.1           | Үндсэн хөрөнгө                          | 337,631,626,575.86        | 368,772,773,055.10        |
| 1.2.2           | Биет бус хөрөнгө                        | 2,382,117,064.85          | 6,609,668,402.55          |
| 1.2.4           | Урт хугацаат хөрөнгө оруулалт           | 15,180,915,748.12         | 13,792,174,613.43         |
| 1.2.6           | Хойшлогдсон татварын хөрөнгө            | 2,276,967,946.38          | 2,577,443,798.60          |
| <b>1.2.10</b>   | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>357,471,627,335.21</b> | <b>391,752,059,869.68</b> |
| <b>1.3</b>      | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>393,948,230,599.61</b> | <b>437,936,937,810.71</b> |
| 2.1.1.1         | Дансны өглөг                            | -                         | 8,126,910,975.24          |
| 2.1.1.3         | Татварын өр                             | 1,238,859,304.62          | 1,348,647,469.07          |
| 2.1.1.8         | Урьдчилж орсон орлого                   | 2,465,063,267.65          | 3,928,911,113.83          |
| 2.1.1.10        | Бусад богино хугацаат өр төлбөр         | 559,743,275.66            | 752,217,698.56            |
| <b>2.1.1.13</b> | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>4,263,665,847.93</b>   | <b>14,156,687,256.70</b>  |
| 2.1.2.1         | Урт хугацаат зээл                       | 131,556,237,619.74        | 154,883,307,180.66        |
| 2.1.2.4         | Бусад урт хугацаат өр төлбөр            | 2,705,656,704             | 7,099,886,402             |
| <b>2.1.2.6</b>  | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | <b>134,261,894,323.91</b> | <b>161,983,193,583.00</b> |
| <b>2.2</b>      | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            | <b>138,525,560,171.84</b> | <b>176,139,880,839.70</b> |
| 2.3.1           | Төрийн өмч                              | 224,711,247,384.81        | 225,778,136,464.28        |
| 2.3.6           | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 17,234,638,136.78         | 20,663,012,633.41         |
| 2.3.8           | Эздийн өмчийн бусад хэсэг               | 3,334,955,559.47          | 6,132,224,920.00          |
| 2.3.9           | Хуримтлагдсан ашиг                      | 10,141,829,346.71         | 9,223,682,953.32          |
| <b>2.3.6</b>    | <b>Эздийн өмчийн дүн</b>                | <b>255,422,670,427.77</b> | <b>261,797,056,971.01</b> |
| <b>2.4</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>393,948,230,599.61</b> | <b>437,936,937,810.71</b> |

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                     | 2024 оны 12 сарын 31      | 2025 оны 12 сарын 31      |
|---------------|--|---------------------------|---------------------------|
| <b>1</b>      | <b>Борлуулалтын орлого(цэвэр)</b>            | <b>147,648,874,030.72</b> | <b>136,629,019,467.05</b> |
| 2             | Борлуулалтын өртөг                           | 97,668,742,039.69         | 86,032,551,684.60         |
| <b>3</b>      | <b>Нийт ашиг(алдагдал)</b>                   | <b>49,980,131,991.03</b>  | <b>50,596,467,782.45</b>  |
| 5             | Хүүний орлого                                | 109,170,217.85            | 188,201,543.94            |
| 8             | Бусад орлого                                 | 3,767,571,960.33          | 4,799,907,895.40          |
| 9             | Борлуулалт, маркетингийн зардал              | 241,948,295.89            | 276,435,937.19            |
| 10            | Ерөнхий удирдлагын зардал                    | 42,622,827,476.00         | 50,647,888,953.40         |
| 11            | Санхүүгийн зардал                            | 4,013,862,820.72          | 5,451,408,821.94          |
| 12            | Бусад зардал                                 | 1,219,530,461.44          | 233,654,341.27            |
| 13            | Гадаад валютын ханшийн зарүүний олз (гарз)   | 8,873.04                  | 141,325.01                |
| 14            | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)   | (1,492,729,377.32)        | (265,386,992.07)          |
| <b>18</b>     | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b> | <b>4,265,984,610.88</b>   | <b>(1,290,056,499.07)</b> |
| 19            | Орлогын татварын зардал                      | 331,547,270.20            | 18,820,154.40             |
| <b>20</b>     | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>       | <b>3,934,437,340.68</b>   | <b>(1,308,876,653.47)</b> |
| <b>22</b>     | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>   | <b>3,934,437,340.68</b>   | <b>(1,308,876,653.47)</b> |
| <b>24</b>     | <b>Орлогын нийт дүн</b>                      | <b>3,934,437,340.68</b>   | <b>(1,308,876,653.47)</b> |

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Өмч                | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн           |
|--|--------------------|-------------------------------------|---------------------------|--------------------|--------------------|
| <b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | 224,711,247,384.81 | 17,380,143,548.78                   | 2,144,263,700.00          | 6,061,886,594.03   | 250,297,541,227.62 |
| Тайланг үеийн цэвэр ашиг   | -                  | -                                   | -                         | 3,934,437,340.68   | 3,934,437,340.68   |
| Бусад дэлгэрэнгүй орлого   | -                  | -                                   | 1,192,589,079.47          | -                  | 1,192,589,079.47   |
| Өмчид гарсан өөрчлөлт  | -                  | -                                   | (1,897,220.00)            | -                  | (1,897,220.00)     |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              | -                  | (145,505,412.00)                    | -                         | 145,505,412.00     | -                  |
| <b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>                               | 224,711,247,384.81 | 17,234,638,136.78                   | 3,334,955,559.47          | 10,141,829,346.71  | 255,422,670,427.77 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 1,066,889,079.47   | -                                   | (1,066,889,079.47)        | (244,362,000.87)   | (244,362,000.87)   |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>   | 225,778,136,464.28 | 17,234,638,136.78                   | 2,268,066,480.00          | 9,897,467,345.84   | 255,178,308,426.90 |
| Тайланг үеийн цэвэр ашиг   | -                  | -                                   | -                         | (1,308,876,653.47) | (1,308,876,653.47) |
| Өмчид гарсан өөрчлөлт  | -                  | -                                   | 3,864,158,440.00          | -                  | 3,864,158,440.00   |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              | -                  | 3,428,374,496.63                    | -                         | 635,092,260.95     | 4,063,466,757.58   |
| <b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>                               | 225,778,136,464.28 | 20,663,012,633.41                   | 6,132,224,920.00          | 9,223,682,953.32   | 261,797,056,971.01 |

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Мөр дугаар | ҮЗҮҮЛЭЛТ  | 2024 оны 12 сарын 31       | 2025 оны 12 сарын 31       |
|------------|---|----------------------------|----------------------------|
| <b>1</b>   | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                          |                            |                            |
| 1.1        | Мөнгөн орлогын дүн (+)  | 170,663,961,625.99         | 166,683,223,602.96         |
|            | Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого                           | 166,981,143,626.38         | 149,312,745,023.20         |
|            | Татаас санхүүжилтийн орлого   | 2,906,191,600.00           | 3,442,817,100.00           |
|            | Бусад мөнгөн орлого   | 776,626,399.61             | 13,927,661,479.76          |
| 1.2        | Мөнгөн зарлагын дүн (-)   | 148,161,612,455.95         | 144,073,119,670.83         |
|            | Ажиллагчдад төлсөн  | 15,311,727,572.00          | 19,685,110,748.81          |
|            | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                                | 4,890,761,210.72           | 6,083,901,670.29           |
|            | Бараа материал худалдан авахад төлсөн                                 | 1,125,854,667.72           | 1,054,788,482.99           |
|            | Ашиглалтын зардалд төлсөн   | 1,931,438,835.84           | 2,089,524,577.57           |
|            | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн                 | -                          | 101,706,460,945.84         |
|            | Татварын байгууллагад төлсөн  | 6,590,066,215.51           | 6,620,375,894.01           |
|            | Бусад мөнгөн зарлага  | 118,311,763,954.16         | 6,832,957,351.32           |
| <b>1.3</b> | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>22,502,349,170.04</b>   | <b>22,610,103,932.13</b>   |
| <b>2</b>   | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |                            |                            |
| 2.1        | Мөнгөн орлогын дүн (+)  | -                          | -                          |
| 2.2        | Мөнгөн зарлагын дүн (-)   | 18,850,381,319.88          | 22,345,112,080.17          |
|            | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                   | 8,163,011,979.15           | 9,371,606,243.70           |
|            | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                       | 10,687,369,340.73          | 12,973,505,836.47          |
| <b>2.3</b> | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>(18,850,381,319.88)</b> | <b>(22,345,112,080.17)</b> |
| <b>4</b>   | <b>Вальютын ханшийн зөрүү</b>   | <b>8,873.04</b>            | <b>(27,561.14)</b>         |
| <b>5</b>   | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       | <b>3,651,976,723.20</b>    | <b>264,964,290.82</b>      |
| <b>6</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>               | <b>4,047,713,701.62</b>    | <b>7,699,690,424.82</b>    |
| <b>7</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>              | <b>7,699,690,424.82</b>    | <b>7,964,654,715.64</b>    |

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

| №  | Үзүүлэлт                                     | Х/н          | 2024 оны гүйцэтгэл   | 2025 оны              |                      | Өөрчлөлт 2025 төл/ 2025 гүйц |              |
|----|--|--------------|----------------------|-----------------------|----------------------|------------------------------|--------------|
|    |  |              |                      | Төлөвлөгөө            | Гүйцэтгэл            | Зөрүү                        | Хувь         |
|    | <b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нэр төрлөөр:</b> | мян. ГДЖ     | 32,891.9             | 34,892.4              | 34,665.9             | (226.5)                      | 99.4         |
| 1  | Борлуулалтын орлого                          | м.төг        | 147,648,874.0        | 132,918,000.0         | 136,629,019.5        | 3,711,019.5                  | 102.8        |
|    | Бусад орлого                                 | м.төг        | 3,876,785.2          | 1,339,700.0           | 4,988,278.3          | 3,648,578.3                  | 372.3        |
| 2  | <b>Нийт орлого</b>                           | <b>м.төг</b> | <b>151,525,659.3</b> | <b>134,257,700.0</b>  | <b>141,617,297.8</b> | 7,359,597.8                  | 105.5        |
| 3  | <b>Нийт зардал</b>                           | <b>м.төг</b> | <b>147,259,674.6</b> | <b>149,581,000.0</b>  | <b>142,926,174.5</b> | (6,654,825.6)                | 95.6         |
|    | Үүнээс: Удирдлагын зардал                    | м.төг        | 286,307.9            | 555,076.0             | 551,008.8            | (4,067.2)                    | 99.3         |
| 4  | <b>Татварын өмнөх ашиг</b>                   | <b>м.төг</b> | <b>4,265,984.6</b>   | <b>(15,323,300.0)</b> | <b>(1,308,876.7)</b> | 14,014,423.4                 | 8.5          |
| 5  | <b>Цэвэр ашиг /алдагдал/</b>                 | <b>м.төг</b> | <b>3,934,437.3</b>   | <b>(15,323,300.0)</b> | <b>(1,308,876.7)</b> | 14,014,423.4                 | 8.5          |
| 6  | Төсвийн төлбөрт нийт дүн                     | м.төг        | 10,999,313.0         | 13,064,868.6          | 13,037,033.2         | (27,835.3)                   | 99.8         |
|    | б/ НӨТ                                       | м.төг        | 4,213,872.0          | 4,514,650.0           | 4,536,866.2          | 22,216.2                     | 100.5        |
|    | в/ НДШ                                       | м.төг        | 4,891,650.8          | 6,107,229.5           | 6,083,901.7          | (23,327.8)                   | 99.6         |
|    | г/ Хүн амын орлогын татвар                   | м.төг        | 1,765,618.1          | 2,280,469.8           | 2,259,614.4          | (20,855.4)                   | 99.1         |
|    | д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар                | м.төг        | 125,049.1            | 162,519.3             | 145,667.1            | (16,852.3)                   | 89.6         |
|    | ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)  | м.төг        | 3,123.0              | -                     | 10,984.0             | 10,984.0                     |              |
| 8  | Ажиллагсдын тоо                              | хүн          | 389.0                | 425.7                 | 406.2                | (19.5)                       | 95.4         |
| 9  | Цалингийн сан                                | м.төг        | 18,898,330.9         | 24,650,742.5          | 24,094,698.0         | (556,044.5)                  | 97.7         |
| 10 | Нэг ажиллагчийн дундаж цалин                 | м.төг        | 4,048.5              | 4,825.9               | 4,943.5              | 117.6                        | 102.4        |
| 11 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал         | м.төг        | 1.0                  | 1.1                   | 1.0                  | (0.1)                        | 93.3         |
| 12 | Хөрөнгө оруулалт                             | м.төг        | 8,130,085.3          | 12,119,800.0          | 11,437,284.7         | (682,515.3)                  | 94.4         |
| 13 | <b>Нийт авлага</b>                           | <b>м.төг</b> | <b>28,326,766.2</b>  | <b>26,710,707.3</b>   | <b>25,967,964.1</b>  | <b>(742,743.2)</b>           | <b>97.2</b>  |
|    | Үүнээс: Найдваргүй                           | м.төг        | 348,376.8            | 375,153.4             | 374,750.7            | (402.7)                      | 99.9         |
| 14 | <b>Нийт өглөг</b>                            | <b>м.төг</b> | <b>138,525,560.2</b> | <b>170,736,100.0</b>  | <b>176,139,880.8</b> | <b>5,403,780.8</b>           | <b>103.2</b> |
|    | Богино хугацаат өр төлбөр                    | м.төг        | 4,263,665.9          | 15,266,600.0          | 14,156,687.7         | (1,109,912.7)                | 92.7         |
|    | Урт хугацаат өр төлбөр                       | м.төг        | 134,261,894.3        | 155,469,500.0         | 161,983,193.6        | 6,513,693.6                  | 104.2        |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1959 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 367 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын дулаацуулах байгууламжийн ашиглалт, засварыг хариуцах үүрэгтэй Дулааны шугам сүлжээний ашиглалтын газар нэртэйгээр анх 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулснаар төвлөрсөн дулаан хангамжийн систем үүсэж, хөгжих эхлэл тавигдсан байна.

Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор Улаанбаатар дулааны сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжин ажиллаж эхэлжээ. Эрчим хүчний зохицуулах газрын 2004 оны 56 дугаар тогтоолоор Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгосон байна.

Тус компани нь 2021 онд “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор шагнагдаж, 2022 онд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо “ISO 9001:2015” стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Компани дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжинд холбогдсон хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй, хэвийн найдвартай хангах, дамжуулах шугам тоноглолын засвар үйлчилгээг чанартай хийх.
- Дулааны эрчим хүчний борлуулалтын орлогыг бүрэн цуглуулах, эх үүсгүүрүүдэд хугацаанд нь төлбөрийг төвлөрүүлэх.
- Дулааны эх үүсгүүрүүдэд боловсруулсан дулааны эрчим хүчний чанарт хяналт тавьж алдагдалгүй дамжуулах.
- Шинээр холбогдох хэрэглэгчдийн барилга, объектын дулааны хэрэглээг судалж, гидравлик тооцоог хийж боломжтой барилгуудад техникийн нөхцөлийг зохих журмын дагуу олгож хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ байгуулж дулаанд холбох.
- Хэрэглэгчийн дулааны шугам тоноглолын засвар, үйлчилгээг чанартай хийлгэж, өвлийн оргил ачааллыг амжилттай давах, дулааны эрчим хүчний ашиглалтын үеийн хяналтыг тогтмол тавьж, зүй бус хэрэглээг бууруулах, хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.
- Дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлттэй уялдуулан дулааны шугам тоноглолын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг төлөвлөх.
- Сүлжээний гидравлик тооцоог хийж горим боловруулах.
- Техникийн шаардлагын дагуу зураг хянаж тодруулга хийх, техник хяналтыг тавих.
- Төв болон салаа шугам хэрэглэгчийн узельд тохируулга, зүгшрүүлгийг хийх.
- Дулааны тоолуурын ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийх, баталгаажуулах.
- Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх.
- Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн системийн горимын тооцоог хийх, тохируулга, зүгшрүүлэг хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна.

Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, 0.7-40.0 кгх/см<sup>2</sup>/ хүртэл даралттай шугам хоолой, дулаан дамжуулах тоноглолын засвар, угсралт түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ, 0.7-40.0 кгх/см<sup>2</sup>/ хүртэл даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, дулааны тоолуур, хэмжих хэрэгслийг суурилуулах, засварлах зэрэг үйл ажиллагаагаа явуулж байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр анхаарч улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр болон өөрийн компанийн хөрөнгөөр ашиглалтын байдал муудсан, насжилтын хугацаа дууссан шугам, тоноглолыг үе шаттайгаар шинэчлэн солих ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд хэдийгээр эх үүсвэр, дамжуулах сүлжээний хүчин чадал хүрэлцэхгүй болсон ч хотын сүлжээг оновчтой схемээр ажиллуулан тохируулга,

зүгшрүүлгийн ажлыг чанартай хийж ажилласны үр дүнд нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай ханган ажиллаж байна.

### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 3 дугаар тогтоол

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллганы зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайлан дах ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нэмэлт өөрчлөлт ороогүй, стандарт, хууль эрх зүйн шаардлагад нийцээгүй, хүчин төгөлдөр бус тогтоол, шийдвэр, журмуудыг үндэслэл болгосон байна. Компанийн онцлог болох гол баримтлах өртөг, зардлын хуваарилалтыг бүртгэх талаар тодорхой заавар, аргачлал тусгагдаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,988.7 сая төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт        |
|--|------------------|------------------|-----------------|
| Б  | 1                | 2                | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                               | 7,699.7          | 7,964.6          | 264.9           |
| Авлага                                       | 27,978.5         | 25,593.2         | (2,385.3)       |
| Бараа материал                               | 681.0            | 721.7            | 40.7            |
| Урьдчилж төлсөн зардал                       | 117.5            | 11,905.3         | 11,787.8        |
| Үндсэн хөрөнгө                               | 357,471.6        | 391,752.1        | 34,280.5        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>393,948.2</b> | <b>437,936.9</b> | <b>43,988.7</b> |
| Өр төлбөр                                    | 138,525.6        | 176,139.9        | 37,614.3        |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 255,422.7        | 261,797.1        | 6,374.4         |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>393,948.2</b> | <b>437,936.9</b> | <b>43,988.7</b> |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,964.6 сая төгрөг болж, 264.9 сая төгрөгөөр өссөн нь хэрэглэгчдэд 28,483.6 мян.жоуль дулааны эрчим хүчийг түгээж, 132,918.0 сая төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 28,579.7 мян.жоул дулааны эрчим хүчийг түгээж, 136,918.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн ба ХАДЭХ-ний хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурсантай уялдан борлуулалт 3,711.0 сая төгрөгөөр өссөн мөн төлөвлөгөөнөөс үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,648.6 сая төгрөгөөр өсөж, зардал 500.9 сая төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэлийн 94.7 хувийг 25,492.9 сая төгрөгийн дулааны эрчим хүчний авлага эзэлж, 1,407.4 сая төгрөг нь ажилчидтай холбоотой болон бусад авлага байна. Эрчим хүчний авлага нь ОСНААУГ, оршин суугчдаас авах 9,100.5 сая төгрөгийн, худалдаа, үйлчилгээний байгууллагаас авах 3,887.1 сая төгрөгийн, үйлдвэрлэлийн байгууллага, өрхийн аж ахуй, айл өрхөөс авах 10,788.1 сая төгрөгийн, төсвийн байгууллагаас авах 97.6 сая төгрөг байгаа бөгөөд бусад авлага хугацаа хэтэрсэн 1,619.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүү, дамжуулан зээлүүлсэн урт хугацаат зээлийн хүүгийн авлага тус тус эзэлж байна. Тайлангийн хугацаанд хэрэглэгчдээс авах дулааны эрчим хүчний авлага төлөвлөгөөнөөс 4.3 хувь буюу 88.2 сая төгрөгөөр буурсан. Тайлант хугацаанд хэрэглэгчдээс авах 1,966.4 сая төгрөгийн авлагын 86.1 хувь буюу 1,693.6 сая төгрөгийн авлага нь Цэцэн бээс ХХК, Тунамал арвижих өргөө ХХК, Дэнж хотхон ХХК, Таункомфорт ХХК, Зайсан скай ХХК-иудаас авах авлага байна. ЭХЗХ-ны тогтоолоор дээрх 5 компанийн тусгай зөвшөөрөл цуцлагдсан байна.

Бараа материалын байнгын систем ашиглаж, дундаж өртгийн аргаар тодорхойлдог. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 40.7 сая төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Үүнд: Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл 18.0 сая төгрөг, механик тоног төхөөрөмж 24.6 сая төгрөгөөр өссөн нь узелийн өргөлтийн насос, лазерийн үзэг бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал өмнөх оноос 11,787.8 сая төгрөгөөр өссөн байна. ЭХЗХ-ноос гаргасан 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 698, 699, 748 дугаар тогтоолуудыг 2025 оны 03 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл мөрдөн ажилласан. Гэтэл ЭХЗХ-ны 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 53-55 дугаар тогтоолуудын дагуу ДЦС 2, 3, 4-өөс 1 ГДж дулаан эрчим хүчийг 1, 2 дугаар саруудад 1,496.0 төгрөгөөр, 3-12 дугаар саруудад 100 төгрөгөөр худалдан авч эхэлсэнтэй холбоотойгоор ДЦС 2,3,4-тэй 11,350.3 сая төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо үүссэн байна.

Компанийн их засвар хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой үүссэн шугамын дулаалгын ажлын эхний санхүүжилтэнд 338.2 сая төгрөг, ариун цэврийн өрөөний засварын ажлын эхний санхүүжилтэнд 157.5 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Мөн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсгүүдэд заасныг баримтлан компаниас улсын тэмдэгтийн хураамжид 34.0 сая төгрөгийг, бусад бэлтгэн нийлүүлэгчээс

## Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

авах 22.8 сая төгрөгийг, шатахууны картны үлдэгдэл 2.8 сая төгрөгийг урьдчилан төлж тооцоо үүссэн байна.

Үндсэн болон биет бус хөрөнгө нь нийт хөрөнгийн 85.7 хувийг эзэлж байна. Өмнөх оноос үндсэн болон биет бус хөрөнгө 34,280.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 05-р сарын 01-ний өдрийн 218 дугаар тогтоолоор хувийн хэвшлийн хуулийн этгээдээс 637.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий ф250мм голчтой шугам хоолойг үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан.

ЕСБХБ-ны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд 4,611.4 сая төгрөгийн Скада хяналтын системтэй цахилгаан активатори бүхий бөмбөлгөн хаалт, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 711 дүгээр тогтоолоор 3,302.2 сая төгрөгийн Бичил хорооллыг хангах дулааны шугам шинээр татах ажил ф400мм голчтой шугам хоолой, нийт 7,913.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн.

Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын дулааны хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 9,019.7 сая төгрөгийн тусгай зориулалтын ачааны автомашин болон 9Г магистраль ф500мм голчтой шугам хоолой, 336.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг тээврийн хэрэгсэл, нийт 9,356.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/274 дугаар тушаалаар батлагдсан 2025 оны их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ны төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 7,749.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

ТӨБЗГ-ын 2025 оны 12 сарын 24-ны өдрийн 855 дугаар тогтоолоор ашиглах боломжгүй, ашиглалтын шаардлага хангахгүй 4,293.2 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 144.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан.

Үндсэн хөрөнгөнд өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,799.3 сая төгрөгийн, Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон ТӨБЗГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 143,621 дүгээр тогтоолоор бүртгэсэн 47,650.8 сая төгрөгийн, Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болгосон ТӨБЗГ-ын 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 295 дугаар тогтоолын дагуу бүртгэсэн 1,842.2 сая төгрөгийн, дуусаагүй барилга данснаас капиталжуулсан 996.9 сая төгрөгийн, Эрчим хүчний зохицуулах хорооны 348 дугаар тогтоолын дагуу 1,213.2 сая төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,294.5 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 655 дугаар тогтоолоор ашиглах боломжгүй болсон, ашиглалтын шаардлага хангахгүй 13,919.8 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Нийт өр төлбөрт 8 хувь буюу 14,156.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 92 хувь буюу 161,983.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 9,893.0 сая төгрөгөөр өссөн. Харин төлөвлөгөөнөөс 7.3 хувиар буюу 1,109.9 сая төгрөгөөр буурсан. Богино хугацаат өр төлбөрийн 57 хувь буюу 8,126.9 сая төгрөг нь Амгалан дулааны станцаас ХАДЭХ-ний өр төлбөр, 28 хувь буюу 3,928.9 сая төгрөг нь урьдчилж орсон орлого, 10 хувь буюу 1,348.6 сая төгрөг нь татварын өглөг, 5 хувь буюу 752.2 сая төгрөг нь бусад өр төлбөр байна.

Татварын өглөгийн хувьд 2024 оны эцэст нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 995.9 сая төгрөг, аж ахуй нэгжийн орлогын албан татварын өглөг 228.3 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөг 14.7 сая төгрөг байсныг 2025 онд бүрэн төсөвт төвлөрүүлж, 2025 оны 12 дугаар сарын борлуулалтаас үүссэн нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 1,341.1 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөг 7.5 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд 7 төрлийн татвар, шимтгэлд 22,626.7 сая төгрөгийн ногдуулалт тооцож 9,589.7 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтын хасалт хийж, 12,927.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

## Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Урт хугацаат өр төлбөр өнгөрсөн оноос 27,721.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх Дэлхийн банкны төслийн ашиглалт, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой. Харин төлөвлөсөн хэмжээнээс 6,513.6 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн. Энэ нь тайлант жил Дэлхийн банкны төслийн ашиглалт, улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой.

2025 онд урт хугацаат өр төлбөр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Дулааны үр ашгийн төсөл, Эрчим хүчний хэмнэлтийн төслийн зээлийн эргэн төлөлт 1,504.8 сая төгрөгөөр, ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн үр ашиг төслийн эргэн төлөлт 2,502.0 сая төгрөгөөр, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын дулааны хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн эргэн төлөлт 621.6 сая төгрөгөөр тус тус буурсан.

2025 онд төлөвлөгөөнөөс 1 ГДж дулааны эрчим хүчний орлого 131.9 төгрөг буюу 3.5 хувиар, өртөг 149.7 төгрөг буюу 3.5 хувиар өссөн байна. Өртгийн өсөлт нь орлогын өсөлтөөс 17.7 төгрөг буюу 13.4 хувиар өссөн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн.

Хуримтлагдсан ашиг өмнөх оноос 918.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд: 2025 онд 1,308.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан ашиг буурч, дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн 635.1 төгрөгөөр нэмэгдэж, бусад авлага дээр бүртгэлтэй шүүхийн шийдвэр гарсан 6 ажилчдад олгосон орон сууцны авлагын дүнгээр өмнөх оны хуримтлагдсан ашиг данс 244.4 сая төгрөгөөр буурч үлдэгдэл 9,223.7 сая төгрөг байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Эрчим хүчний сайдын 2025 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан компанийн 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 132,918.0 сая төгрөгийн борлуулалттай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 136,629.0 сая төгрөгийн борлуулалт хийж, төлөвлөсөн хэмжээнээс 3,711.0 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн үзүүлэлт гарсан. Борлуулалтын орлого өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд:

- Горим ажиллагааг оновчтой хувилбараар зөв зохион байгуулалттай тооцож ажилласны үр дүнд дулааны эрчим хүчний алдагдлыг 0.8 пунктээр буюу 4.6 хувиар бууруулан ажиллаж 1,342.5 сая төгрөгийн орлого нэмэгдсэн,
- ДЭХ-ний шинэ хэрэглээ, эх үүсвэрийн өөрчлөлтөөс шалтгаалж 2,368.5 сая төгрөг тус тус нэмэгдсэн.

Хэрэглэгчдэд 28,483.6 мян.жоуль дулааны эрчим хүчийг түгээж, 132,918.0 сая төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 28,579.7 мянган жоулийг түгээж, 136,918.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь ХАДЭХ-ний хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурсантай уялдан борлуулалт 3,711.0 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс өссөн.

Тайлант жилд 141,617.3 сая төгрөгийн орлого олж, зардалд 142,926.2 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн дүнгээр 1,308.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба энэ нь төлөвлөсөн алдагдлыг 14,014.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

Худалдан авсан дулааны эрчим хүчний өртөгт 87,711.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 86,032.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, 2.0 хувь буюу 1,738.9 сая төгрөгөөр буурсан нь ХАДЭХ-ний биет хэмжээ буурсантай холбоотой.

Түгээх хангах үйл ажиллагааны зардалд 61,010.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 56,595.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, 4,414.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан.

Төлөвлөгөөнөөс үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,648.6 сая төгрөгөөр өсөж, зардал 500.9 сая төгрөгөөр буурсан байна.

Төлөвлөгөөнөөс үндсэн үйл ажиллагааны алдагдал 9,864.9 сая төгрөгөөр буурч 5,999.4 сая төгрөгийн алдагдалтай, үндсэн бус үйл ажиллагаагаар ашиг 4,149.5 сая төгрөгөөр өсөж 4,690.5 сая төгрөгийн ашигтай, татвар төлөхийн өмнөх алдагдал 14,014.4 сая төгрөгөөр өсөж 1,308.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд борлуулалтын авлага цуглуулалтыг 101.1 хувиар төлөвлөн, 101.5 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, 26,710.7 сая төгрөгийн зорилтот түвшинд тусгагдсан авлагыг 2.8 хувиар буюу 742.7 сая төгрөгөөр бууруулан 25,968.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Нийт өр төлбөрийг 170,736.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 176,139.9 сая төгрөг болж, 5,403.8 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 удаа тодотгол хийсэн. Ингэснээр тайлант онд 79 төрлийн ажлыг 12,119.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 71 нэр төрлийн ажлыг 11,437.3 сая төгрөгөөр гүйцэтгэж, 682.3 сая төгрөгийн хэмнэлт гарсан.

Дулааны эрчим хүчний мөнгөн урсгал 17,593.1 сая төгрөгөөр буурсан нь ЭХЗХ-ний 2025 оны тусгай зөвшөөрөл эзэмшигч 59 хувийн орон сууцны компани, ОСНААУГ-т борлуулах дулааны эрчим хүчний 1 жоулийн дундаж тарифыг бууруулсантай холбоотой.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус компанийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зорилтот түвшнийг алдагдалгүй төлөвлөн батлах, авлага цуглуулах эргэцийг богиносгох, зардлыг үр ашигтай зарцуулах зэрэг өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Янжмаа, аудиторын туслах П.Сувд-эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Долгорсүрэн, компанийн захирал Б.Пүрэвдулам нар анхан шатны чанарын хяналтыг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямсүрэн, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/289 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 147,259.6 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож 1,472.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзэхэд шинж чанар материаллаг өөрчлөлтгүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь үр ашигт байдлыг ханган, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал болон шугамын алдагдлыг бууруулах, өртөг зардлыг хэмнэж ажилласнаар түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг тухай бүр хянаж, дүн шинжилгээ хийж ажилласнаар гүйцэтгэлээр 28 төрлийн зардлыг 4,414.9 сая төгрөгөөр хэмнэсэн.

Компани тайлант онд 34,892.4 мян.ГДж дулааны эрчим хүчийг 87,771.5 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 34,665.9 мян.ГДж дулааны эрчим хүчийг 86,032.6 сая төгрөгөөр худалдан авч 226.4 мян.ГДж буюу 1,738.9 сая төгрөгийг хэмнэн ажилласан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК өнөөдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 09 тоот тогтоолоор бүтэц, орон тооны дээд хязгаарыг 426 орон тоотой ажиллахаар батлан Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/106 дугаар тушаалаар бүтэц, зохион байгуулалтын хувьд удирдлага болон 23 алба, хэлтэс, төв, нэгжийн нийт 426

ажиллагсадтай байхаар батлагдсанаас гүйцэтгэлээр 406 ажилтантай ажиллаж орон тооны хэмнэлттэй ажиллаж, нийт 389 инженер техникийн ажилтан, албан хаагчтай ажиллаж байна.

2. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8.2, 8.4, Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/274 тушаалыг үндэслэн Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусганаар нэг өдрийн албан хаагчдын ажилдаа ирэх буцах нийтийн тээврийн унааны зардлыг нэг өдрийн 1.0 мянган төгрөг, хоолны зардлыг 9.0 мянган төгрөг, нийт төлөвлөгөөгөөр 879.0 сая төгрөг төлөвлөн гүйцэтгэлээр 853.7 сая төгрөг зарцуулж 25.2 сая төгрөг хэмнэсэн байна.
4. Гадаад албан томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардлын тухайд 26.0 сая төгрөгийг гурван удаагийн зардлаар төлөвлөн 25.4 сая төгрөг байна.
5. Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаагаар Siemens Wincc Tiaportal V18 /Алсын зайн хяналт удирдлагын систем СКАДА/, Zulu Thermo 2021 хувилбар /Дулааны сүлжээний горим тооцоо/, ABB automation builder программын лиценз /ABB алсын зайн хяналт удирдлагын систем/ үйл ажиллагаанд хэрэглэж байна. Эдгээр программууд нь 425.4 сая төгрөгийн өртөгтэй. Санхүүгийн үйл ажиллагаанд санхүү бүртгэлийн Интерактив Би Ай ХХК-ийн Даймонд 5.0 програмыг 2012 оноос хойш ашиглаж ирсэн. Гэтэл 2025 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр компанийн санхүү бүртгэлийн програм, горим тооцооны програм байрлах сервер халдлагад өртсөн. Тус хадлага Medusalocker бүлгийн Ransomware хортой програмаар үйлдэгдсэн ба програм хангамжуудын өгөгдлийн сан, нөөц файлуудын хамт энсгүрт хийж ашиглах боломжгүй болгосон. Компани 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр халдлагад өртсөн сервер компьютерыг сүлжээнээс тусгаарлаж, ТЭГ-ийн Мэдээллийн аюулгүй байдлын газар, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх газарт мэдэгдсэн. Тус халдлагатай холбоотой Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх газрын мэргэжилтнүүд ирж үзлэг хийсэн. Мөн тус газраас APCERT /Ази номхон далайн бүсийн кибер аюулгүй байдлын зөвлөл/-ийн гишүүн орнуудруу тус халдлагын талаар мэдээлэл илгээж тодруулга авсан ба шинэ төрлийн ransomware тул тайлах боломжгүй байгаа тухай мэдэгдсэн байна. Тус хадлага Medusalocker бүлгийн Ransomware хортой програмаар үйлдэгдсэн ба програма хангамжуудын өгөгдлийн сан, нөөц файлуудын хамт энсгүрт хийж ашиглах боломжгүй болгосон. Тус халдлагаар 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны санхүү бүртгэлийн програмын өгөгдөл сэргээх боломжгүй болсон. Санхүүгийн програм шинэчлэн солихоор Эрчим хүчний сайдын А/11, А/274 дугаар тушаалаар компанийн 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд санхүүгийн програм шинэчлэх 100.0 сая төгрөгийг 2026 онд санхүүжүүлэхээр батлагдсан байсан. Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/104 дугаар тушаалаар Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа Компанийн чадавхийг дэмжих зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гэрээний биелэлтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээр санхүүгийн програмыг үүлэн технологийг ашиглан ERP системд суурилсан шинэчилсэн санхүүгийн програмыг авахаар техникийн даалгаврыг ҮБХ-ийн программ хангамжийн инженерүүдтэй хамтран гаргахаар ажиллаж байсан. Ингээд халдлагад өртсөн санхүүгийн програмыг сэргээх боломжгүй болсон тул ажлын хэсэг, Номадик Нью Энержи ХХК-тай хамтран ажиллаж Artlab ERP системийг сонгож, Артлаб ХХК-тай гэрээ байгуулсан. Програмын мэдээллийн баазыг эрсдэлээс хамгаалж өдөр болгон архив байдлаар нөөцөлж аюулгүй хадгалах, Айтүүлс ХХК ийн “Дата төв”-д байрлах өөрийн серверүүд дээрх програм хангамж, үйлдлийн системийн хамгийн сүүлийн үеийн технологийг

ашиглан гадаад интернэт болон дотоод сүлжээн дэх аюулгүй байдал, хамгаалалтыг өндөр төвшинд авч ажиллахаар гэрээнд зааж тохиролцсон байна. Artlab ERP системд хэрхэн нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөөгөө батлаад 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнөх 2024 оны эцсийн үлдэгдлийг данс бүрээр оруулж эхэлсэн. Ингээд Artlab ERP системээс 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс харилцах дансны зарлагын гүйлгээг шивж, хэвлэж гүйлгээнд ашигласан. Компанийн эдийн засаг, санхүү бүртгэлийн хэлтсийн 9 нягтлан бодогч, 2 нярав нар ажиллаж 2025 оны бүх гүйлгээг бүрэн Artlab ERP системд оруулж санхүүгийн тайлан гаргахад бэлэн болсон байна.

6. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 60 удаагийн үйл ажиллагаанд 330.1 сая төгрөг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 63 удаагийн үйл ажиллагааг 230.7 сая төгрөгөөр зохион байгуулсан байна.
7. Хэвлэл мэдээллийн 7 байгууллагатай Дулааны эрчим хүчний үнэ тарифтай холбоотой бодит мэдээлэл түгээх, ярилцлага, нийтлэл бэлтгэх, Эрчим хүчний тариф нэмэгдсэнээс хойших хугацаанд эрчим хүчний салбарт үүсэж буй давуу талуудыг олон нийтэд сурталчлах, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, эрдсэлээс урьдчилан сэргийлүүлэх, эрчим хүчний хамгаалалтын зурвасын талаар контент бэлтгэн түгээх, Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн үйл ажиллагаа, эрчим хүчний салбарын реформ сэдвийн хүрээнд 124.6 сая төгрөг төлөвлөн гүйцэтгэлээр 119.2 сая зарцуулсан байна.
8. Тайлант хугацаанд хамаарах төрд учирсан хохирол байхгүй.
9. Хамтын гэрээнд хууль, журам дах заалтаас давсан заалтууд байгаа эсэх судалгааны үр дүнд зөрчилтэй асуудал илрээгүй ба Эрчим хүчний салбарын 2025-2026 оны хамтын хэлэлцээрт үндэслэн шинэчлэн баталсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

*Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 161 мэдээлэл мэдээлэхээс Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 мэдээ, дараа жилийн зорилтот түвшин 1, байгууллагын батлагдсан төсөв 1, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 нийт 270,825.2 сая төгрөгийн дүнтэй 4 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаандаа байршуулаагүй тул холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны 05 дугаар сарын 19-ний өдөр Маргад Эрчим ХХК-тай гэрээ байгуулахдаа 117.6 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан, тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасны дагуу санал болгож буй барааг өөрийн хөрөнгөөр нийлүүлэх тухай нотлох баримт ирүүлээгүйг тэмдэглэсэн боловч тендерийг дахин зарлаагүй санал хураалтаар шалгаруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна", 28 дугаар зүйлийн 28.1.1-т "Хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох", 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 28.6-д "Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гүйцэтгэлийн баталгааг гэрээ батлагдсанаас хойш нөхөн авсан, хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчийг хууль зөрчин сонгосон, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд илэрсэн зөрчил нь холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллага нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2025 оны 04 дүгээр сарын 01, 03-ны өдрүүд, 05 дугаар сарын 08-ны өдөр Некст Стандарт ХХК, Бишрэлт Түмэн Хаан ХХК, Дунди ХХК-уудтай тус тус гэрээ байгуулахдаа нийт 460.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан нь гэрээний биелэлт болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна", 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 28.6-д "Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гүйцэтгэлийн баталгааг гэрээ батлагдсанаас хойш нөхөн авсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд илэрсэн зөрчил нь холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, авлага, бараа материал, зардлын бүртгэл, анхан шатны баримт, худалдан авах ажиллагаатай холбоотой дансад горим, сорил хэрэгжүүлж, аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 267.1 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Хэрэгжүүлээгүй 5 зөрчлийг тайлангийн илрүүлэлт хэсэгт тусгав.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 22.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 22.6 сая төгрөгийн 1 акт, 84.4 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэнг 100.0 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитаар өгсөн |              | Биелэлт  |              |              |
|-----------------|----------------------|--------------|----------|--------------|--------------|
|                 | Тоо                  | Дүн          | Тоо      | Дүн          | Хувь         |
| Акт             | 1                    | 22.6         | 1        | 22.6         | 100.0        |
| Албан шаардлага | -                    | -            | -        | -            | -            |
| Зөвлөмж         | 2                    | 84.4         | 2        | 84.4         | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>3</b>             | <b>107.0</b> | <b>3</b> | <b>107.0</b> | <b>100.0</b> |

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт хугацаандаа ирүүлж бүрэн хэрэгжүүлж ажилласан боловч 22.6 сая төгрөгийн төлбөрийн актыг байгууллагаас төлж, авлагаар бүртгэсэн байна. Энэ актын асуудал шүүхийн шатанд яваа бөгөөд маргаан шийдвэрлэгдээгүй байна.

Тайлант онд Үйлдвэрчний эвлэлийн даргын цалин урамшууллыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шаардлагаар дахин 19.2 сая төгрөгөөр олгосон байсан. Энэ маргаан эцэслэн шийдвэрлээгүй гэж үзэн асуудлын бүртгэлд тусгаагүй.

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага Эрчист монгол ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хийсэн Менежментийн гэрээний төлбөр 139.5 сая төгрөг төлсөн ба 2026 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдсэн байна. Энэ гэрээний үр дүнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг шалгах, хэрэгжилтийг үнэлэх, үндэслэл бүхий зардал эсэхийг тогтоох, гэрээний хяналт хэрэгжүүлэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 573.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 267.1 сая төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Бараа материалын биет тооллогоор хангамжийн материалын агуулахад 9.5 сая төгрөгийн 39 ширхэг угаалгын нунтаг, 132 ширхэг 13 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл илүү байсан ба тухайн бараа материалын хөдөлгөөн бүртгэгдээгүй, хяналтын алдаа байх магадлалтай тул илүү байгаа бараа материалыг дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй.
- Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нь 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Медика монголиа ХХК, Маргад Эрчим ХХК-тай гэрээнүүд байгуулсан боловч гэрээний гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, харин гүйцэтгэлийн баталгааг гэрээний хэрэгжилтээс хойш нөхөн авсан нь холбогдох хууль зөрчсөн, гэрээний биелэлт болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна”, 42.1-т “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, 28.6-д “Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй.

Аудитаар нийт 306.4 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 305.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 306.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Бараа материалын биет тооллогоор хангамжийн материалын агуулахад илүү байсан эмнэлгийн хэрэгслийг хугацаа дууссан тул устгаж, бусад угаалгын нунтгийг бүртгэж, 381 ширхэг 0.6 сая ажлын бээлийг алга болсон гэх шалтгаанаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 5.1.5-т “Хэмжигдэхүйц байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсний 14.4.1 дэх “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын биет тооллогоор дутсан 381 ширхэг ажлын бээлийний 0.6 сая төгрөгийг аж ахуйн нярав У.Түмэн-өлзийгөөр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайланд бүртгэлтэй насжилт өндөр буюу 361 хоногоос дээш насжилттай 1,429.4 сая төгрөгийн борлуулалтын авлагыг шүүхийн шийдвэр гаргуулахаар бүрдүүлэлт хийж байгаа боловч 305.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг гэрээ шилжсэн, гэрээгүй гэх тайлбартайгаар барагдуулах чиглэлээр нэхэмжлэх гаргах, гэрээний дагуу хариуцлага тооцох, шүүхэд хандах зэрэг арга хэмжээ аваагүй, авлагыг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-т “Төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг гэрээ шилжсэн, гэрээгүй гэх тайлбартайгаар барагдуулах чиглэлээр нэхэмжлэх гаргах, гэрээний дагуу хариуцлага тооцох, шүүхэд хандах зэрэг арга хэмжээ аваагүй, авлагыг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг албан шаардлага хүргүүлээ.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган Үндэсний аудитын газарт ирүүлж биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга  | Нийт алдаа |              | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |          | Үүнээс     |              |              |          | Зөвлөмж  |          |
|--|------------|--------------|-----------------------------------|----------|--------------------------|----------|------------|--------------|--------------|----------|----------|----------|
|  | Тоо        | Дүн          | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн      | Залруулсан |              | Залруулаагүй |          | Тоо      | Дүн      |
|  |            |              |                                   |          |                          |          | Тоо        | Дүн          | Тоо          | Дүн      |          |          |
| Бараа материалын биет тооллогоор хангамжийн материалын агуулахад 39 ширхэг угаалгын нунтаг, 132 ширхэг 13 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл илүү байсан ба тухайн бараа материалын хөдөлгөөн бүртгэгдээгүй, бараа материалыг дансанд бүртгэлгүй байна.                            | 1          | 9.5          | -                                 | -        | -                        | -        | 1          | 9.5          | -            | -        | -        | -        |
| Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нь 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Медика монголиа ХХК, Маргад Эрчим ХХК-тай гэрээнүүд байгуулсан боловч гэрээний гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, харин гүйцэтгэлийн баталгааг гэрээний хэрэгжилтээс хойш нөхөн авсан байна. | 1          | 257.6        | -                                 | -        | -                        | -        | 1          | 257.6        | -            | -        | -        | -        |
| <b>Дүн</b>   | <b>2</b>   | <b>267.1</b> | <b>-</b>                          | <b>-</b> | <b>-</b>                 | <b>-</b> | <b>2</b>   | <b>267.1</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |              | Үүнээс        |            |                 |              |         |     |                                      |                     |   |     |
|--|-------------|--------------|---------------|------------|-----------------|--------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |              | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |              | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн          | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Бараа материалын биет тооллогоор хангамжийн материалын агуулахад илүү байсан эмнэлгийн хэрэгслийг хугацаа дууссан тул устгаж, бусад угаалгын нунтгийг бүртгэж, 381 ширхэг 0.6 сая ажлын бээлийг алга болсон гэх шалтгаанаар бүртгээгүй байна.  | 1           | 0.6          | 1             | 0.6        | -               | -            | -       | -   | 1                                    | 1                   | -   | -   |
| Санхүүгийн тайланд бүртгэлтэй насжилт өндөр буюу 361 хоногоос дээш насжилттай 1,429.4 сая төгрөгийн борлуулалтын авлагыг шүүхийн шийдвэр гаргуулахаар бүрдүүлэлт хийж байгаа боловч 305.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг гэрээ шилжсэн, гэрээгүй гэх тайлбартайгаар барагдуулах чиглэлээр нэхэмжлэх гаргах, гэрээний дагуу хариуцлага тооцох, шүүхэд хандах зэрэг арга хэмжээ аваагүй, авлагыг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна. | 1           | 305.8        | -             | -          | 1               | 305.8        | -       | -   | 1                                    | 1                   | -   | -   |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>306.4</b> | <b>1</b>      | <b>0.6</b> | <b>1</b>        | <b>305.8</b> |         |     | <b>2</b>                             | <b>2</b>            |   |     |

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                  | Үүнээс        |          |                 |              |          |                  |
|--|-------------|------------------|---------------|----------|-----------------|--------------|----------|------------------|
|  |             |                  | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |              | Зөвлөмж  |                  |
|  | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн          | Тоо      | Дүн              |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>  |             |                  |               |          |                 |              |          |                  |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 161 мэдээлэл мэдээлэхээс Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 мэдээ, дараа жилийн зорилтот түвшин 1, байгууллагын батлагдсан төсөв 1, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 нийт 4 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн байна.   | 1           | 270,825.2        |               |          |                 |              | 1        | 270,825.2        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>270,825.2</b> |               |          |                 |              | <b>1</b> | <b>270,825.2</b> |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>  |             |                  |               |          |                 |              |          |                  |
| Тайлант оны 05 дугаар сарын 19-ний өдөр Маргад Эрчим ХХК-тай гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан, тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасны дагуу санал болгож буй барааг өөрийн хөрөнгөөр нийлүүлэх тухай нотлох баримт ирүүлээгүйг тэмдэглэсэн боловч тендерийг дахин зарлаагүй санал хураалтаар шалгаруулсан байна. | 1           | 117.6            | -             | -        | 1               | 117.6        | -        | -                |
| Байгууллага нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2025 оны 04 дүгээр сарын 01, 03-ны өдрүүд, 05 дугаар сарын 08-ны өдөр Некст Стандарт ХХК, Бишрэлт Түмэн Хаан ХХК, Дунди ХХК-уудтай тус тус гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан байна.  | 1           | 460.8            | -             | -        | 1               | 460.8        | -        | -                |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>578.4</b>     | <b>-</b>      | <b>-</b> | <b>2</b>        | <b>578.4</b> | <b>-</b> | <b>-</b>         |
| <b>Нийт дүн</b>  | <b>3</b>    | <b>271,403.6</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>2</b>        | <b>578.4</b> | <b>1</b> | <b>270,825.2</b> |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 160/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/69/НА-СТА-ТВА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын биет тооллогоор хангамжийн материалын агуулахад илүү байсан эмнэлгийн хэрэгслийг хугацаа дууссан тул устгаж, бусад угаалгын нунтгийг бүртгэж, 381 ширхэг 596,474.55 (таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун далан дөрвөн төгрөг тавин таван мөнгө)-ний ажлын бээлийг алга болсон гэх шалтгаанаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.3.2-т "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 5.1.5-т "Хэмжигдэхүйц байх", 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэсний 14.4.1 дэх "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7-д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Бараа материалын биет тооллогоор дутсан 381 ширхэг ажлын бээлийний 596,474.55 (таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун далан дөрвөн төгрөг тавин таван мөнгө)-ийг аж ахуйн нярав У.Түмэн-өлзийгөөр нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг, нотлох баримтын хамт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Амарсанаа), ерөнхий нягтлан бодогч (Г.Гантуул) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z\_Akt2026\_0316\_SAG-18.Docx

152600177



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 705/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/69/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй насжилт өндөр буюу 361 хоногоос дээш насжилттай 1,429,391,281.00 (Нэг тэрбум дөрвөн зуун хорин есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун наян нэгэн) төгрөгийн борлуулалтын авлагыг шүүхийн шийдвэр гаргуулахаар бүрдүүлэлт хийж байгаа боловч 305,814,176.26 (Гурван зуун таван сая найман зуун арван дөрвөн мянга нэг зуун далан зургаан төгрөг хорин зургаан мөнгө)-ний авлагын үлдэгдлийг гэрээ шилжсэн, гэрээгүй гэх тайлбартайгаар барагдуулах чиглэлээр нэхэмжлэх гаргах, гэрээний дагуу хариуцлага тооцох, шүүхэд хандах зэрэг арга хэмжээ аваагүй, авлагыг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-т "Төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг гэрээ шилжсэн, гэрээгүй гэх тайлбартайгаар барагдуулах чиглэлээр нэхэмжлэх гаргах, гэрээний дагуу хариуцлага тооцох, шүүхэд хандах зэрэг арга хэмжээ аваагүй, авлагыг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Амарсанаа), ерөнхий нягтлан бодогч (Г.Гантуул) нарт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026 0316 SAG-28 Docx

1526180843



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 706/A015 0092

Улаанбаатар хот

САГ - 2026/69/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллага нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2025 оны 04 дүгээр сарын 01, 03-ны өдрүүд, 05 дугаар сарын 08-ны өдөр Некст Стандарт ХХК, Бишрэлт Түмэн Хаан ХХК, Дунди ХХК-уудтай тус тус гэрээ байгуулахдаа нийт 460,764,998.00 (Дөрвөн зуун жаран сая долоон зуун жаран дөрвөн мянга есөн зуун ерэн найман) төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан нь гэрээний биелэлт болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна", 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 28.6-д "Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно". гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3 заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гүйцэтгэлийн баталгааг гэрээ батлагдсанаас хойш нөхөн авсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Амарсанаа), ерөнхий нягтлан бодогч (Г.Гантуул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026 0316.SAG-28 Docx

1526180845



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 707/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/69/НА - СТА - ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 05 дугаар сарын 19-ний өдөр Маргад Эрчим ХХК-тай гэрээ байгуулахдаа 117,560,000.00 (Нэг зуун арван долоон сая таван зуун жаран мянган) төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гэрээ батлагдсанаас хойш гүйцэтгэлийн баталгааг нөхөн авсан, тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасны дагуу санал болгож буй барааг өөрийн хөрөнгөөр нийлүүлэх тухай нотлох баримт ирүүлээгүйг тэмдэглэсэн боловч тендерийг дахин зарлаагүй санал хураалтаар шалгаруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна", 28 дугаар зүйлийн 28.1.1-т "Хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох", 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 28.6-д "Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3 заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг урьдчилан шаардаагүй, гүйцэтгэлийн баталгааг гэрээ батлагдсанаас хойш нөхөн авсан, хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчийг хууль зөрчин сонгосон, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Амарсанаа), ерөнхий нягтлан бодогч (Г.Гантуул) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Б.ПҮРЭВДУЛАМ